| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                                            | 241,000.00            | 253,222.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо                                                         | 198,000.00            | 176,000.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                       | 768,500.00            | 5,574,070.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                | <b>20,528,410.00</b>  | <b>28,863,100.00</b>  |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                     | 19,229,410.00         | 28,863,100.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                               | <b>295,985,471.83</b> | <b>170,672,900.06</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                         | <b>85,614,100.00</b>  | <b>160,973,400.00</b> |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                                        | 0.00                  | 48,560,800.00         |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 0.00                  | 21,083,200.00         |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 83,964,100.00         | 90,005,400.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                               | 1,650,000.00          | 1,324,000.00          |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                    | <b>210,371,371.83</b> | <b>9,699,500.06</b>   |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                                 | 209,208,021.83        | 9,699,500.06          |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>                            | <b>3,998,000.00</b>   | <b>20,000,000.00</b>  |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>                                      | <b>3,998,000.00</b>   | <b>20,000,000.00</b>  |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                               | <b>3,998,000.00</b>   | <b>20,000,000.00</b>  |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                            | <b>3,998,000.00</b>   | <b>20,000,000.00</b>  |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                                        | 3,998,000.00          | 20,000,000.00         |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>                          | <b>-3,998,000.00</b>  | <b>-20,000,000.00</b> |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код         | Үзүүлэлт                                                             | Төлөвлөгөө              | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|----------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>2,000,586,200.00</b> | <b>1,952,720,549.94</b>     |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                 | <b>2,000,586,200.00</b> | <b>1,952,720,549.94</b>     |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>1,839,612,300.00</b> | <b>1,791,747,149.94</b>     |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>1,057,629,000.00</b> | <b>1,036,081,228.23</b>     |
| 210101      | Үндсэн цалин                                                         | 677,859,800.00          | 765,576,127.49              |
| 210102      | Нэмэгдэл                                                             | 270,093,100.00          | 176,993,790.42              |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                                | 46,926,000.00           | 39,543,661.97               |
| 210104      | Урамшуулал                                                           | 62,750,100.00           | 53,967,648.35               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>142,780,000.00</b>   | <b>137,937,220.21</b>       |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                   | 100,474,800.00          | 95,237,086.75               |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                   | 10,576,300.00           | 10,621,754.70               |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 8,461,000.00            | 8,946,323.54                |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                 | 2,115,300.00            | 2,102,915.27                |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                | 21,152,600.00           | 21,029,139.95               |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>509,321,500.00</b>   | <b>506,364,375.51</b>       |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                     | 10,393,900.00           | 10,341,122.51               |
| 210302      | Түлш, халаалт                                                        | 477,587,600.00          | 477,554,033.00              |
| 210303      | Цэвэр, бохир ус                                                      | 21,340,000.00           | 18,469,220.00               |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>21,975,000.00</b>    | <b>16,878,764.99</b>        |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 2,698,900.00            | 2,346,299.99                |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 2,627,200.00            | 2,500,000.00                |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 2,638,100.00            | 1,807,715.00                |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 5,472,900.00            | 2,249,000.00                |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 8,537,900.00            | 7,975,750.00                |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                              | <b>36,581,600.00</b>    | <b>29,831,800.00</b>        |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 164,200.00              | 164,200.00                  |
| 210502      | Хоол, хүнс                                                           | 32,712,000.00           | 26,013,000.00               |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                          | 3,705,400.00            | 3,654,600.00                |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>27,907,200.00</b>    | <b>26,563,250.00</b>        |
| 210604      | Урсгал засвар                                                        | 27,907,200.00           | 26,563,250.00               |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | <b>828,600.00</b>       | <b>781,200.00</b>           |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 828,600.00              | 781,200.00                  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>11,595,600.00</b>    | <b>8,446,211.00</b>         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,455,800.00            | 1,758,119.00                |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                                  | 743,000.00              | 684,800.00                  |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 420,000.00              | 253,222.00                  |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо                                        | 450,000.00              | 176,000.00                  |

|             |                                                                                       |                         |                         |
|-------------|---------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                       | 5,614,800.00            | 5,574,070.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                | <b>30,993,800.00</b>    | <b>28,863,100.00</b>    |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                     | 30,993,800.00           | 28,863,100.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                               | <b>160,973,900.00</b>   | <b>160,973,400.00</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                         | <b>160,973,900.00</b>   | <b>160,973,400.00</b>   |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                                        | 48,560,800.00           | 48,560,800.00           |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 21,083,300.00           | 21,083,200.00           |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 90,005,400.00           | 90,005,400.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                               | 1,324,400.00            | 1,324,000.00            |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                 | <b>2,000,586,200.00</b> | <b>1,952,720,549.94</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                                        | <b>1,955,586,200.00</b> | <b>1,948,886,699.94</b> |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих                                                               | 1,955,586,200.00        | 1,948,886,699.94        |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                                          | <b>45,000,000.00</b>    | <b>3,833,850.00</b>     |
| 350002      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                             | 30,000,000.00           | 3,833,850.00            |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                                                     | Гүйцэтгэл           |
|-------------|------------------------------------------------------------------------------|---------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                     | <b>300,000.00</b>   |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                         | <b>300,000.00</b>   |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | 300,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                      | 300,000.00          |
| 210404      | Ном, хэвлэл                                                                  | 300,000.00          |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                         | <b>3,000,000.00</b> |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг               | 3,000,000.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                        | 3,300,000.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                           | 3,300,000.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,300,000.00        |



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадамжтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлдэг үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,884.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 36.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 30.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 2,258.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 45.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 36.0 сая төгрөгөөр тооцлоо. Мөн эдийн засгийн ангилал зөрчин хийсэн гүйлгээ, төсвөөс зориулалт бусаар гаргасан зөрчлүүдийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзлээ.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67 хувиар буюу 3,234.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материал дансны үлдэгдэл 571.8 сая төгрөг болж 47.5 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал хасагдсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 48.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 7.2 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 103.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.9 сая төгрөгийн эмийг акталж устгасан байна. Оны эцэст 571.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,451.8 сая төгрөг болж 54.9 сая төгрөгөөр өссөн нь 91.2 сая төгрөгийн барилгын засвар хийгдсэн, бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй хөрөнгө ирсэнтэй холбоотой. Хандиваар 31.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж авч, бусад эх үүсвэрээс 60.0 сая төгрөгийн барилгын сайжруулалт хийж, 36.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Авлага дансанд эхний үлдэгдэл 13.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10.3 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой цалин, бараа материалын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Өглөг дансанд эхний үлдэгдэл 1.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 19.8 сая төгрөг болж өссөн нь оны эцэст ХХОАТ, НДШ-ын өглөгтэй гарснаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,214.2 сая төгрөг болж 1,277.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 4 хувиар буюу 76.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй авсан хөрөнгө буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -104.1 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,253.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 252.8 сая төгрөгөөр бууруулж, 2,000.5 сая төгрөгөөр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 2,000.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,955.5 сая төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын орлогоос 45.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,955.5 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 3.8 сая төгрөгийг авч, урсгал үйл ажиллагаанд 1,952.7 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 6.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Төсөвт байгууллагын өөрийн орлого 41.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 47.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 21.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 5.0 сая төгрөгөөр, нормативд зардлыг 6.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 3.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.1 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 1.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 3.3 сая төгрөг орсноос 3.0 сая төгрөгийг улсын төсөвт, төвлөрүүлж, 0.3 сая төгрөгийн ном хэвлэл худалдан авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу

тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 1,513.1 сая төгрөгийн 55 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 955.6 сая төгрөгийн 19 мэдээллийг ил тод бүрэн байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 12.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19.4 сая төгрөгийн албан шаардлага, 15.6 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан байна. Өмнөх шийдвэрийн үлдэгдэлгүй боловч давтан гарсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараа жилийн аудитаар төсвийн хэмнэлтийн горим, бараа материалын тайлангийн тулгалт, авлагын барагдуулалт, цалингийн тооцооллыг шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 171.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 123.9 сая төгрөгийн алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 43.1 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Тайлант онд санхүүгийн тайланд дараах залруулгыг хийлээ. Барилгын дээврийн засвар 20.0 сая төгрөгийг орлого аваагүй, шууд зардалд бичсэнийг үндсэн хөрөнгийн тайланд сайжруулалтаар бүртгэсэн.

Бараа материалын тайлангийн барилгын засварын материал -11.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй

Акталж устгасан бараа материал 36.1 сая төгрөгийг тодруулга тайланд зарцуулснаар тайлагнасан

Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд 6.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан

Бараа материалын тайланд үнэ төлбөргүй авсан 6.8 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүнийг худалдан авснаар тайлагнасан



ХНХЯ-аас 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын засварын ажил хийгдсэн байхад түүнийг НББ-д тусгаагүй байна

Нэмэлт санхүүжилтийн орлого 3.3 сая төгрөгийг үндсэн дансанд орсон орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан

#### 4.2 Төлбөрийн акт

Спортын наадмын биеийн тамирын хувцас авахад 3.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.3 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо. Ажиллагсдаас 0.45 төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 9.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" /Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 6.7 сая төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагаас багш нарын магистрын төлбөрт 5.3 сая төгрөгийг төлсөн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" МСҮТ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/13 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.13-д "Докторын сургалтад хамрагдсан

багш, ажилтанд байгууллага сургалтын төлбөрийн 50 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлнэ /Хугацаандаа цол хамгаалаагүй болон цол хамгаалчхаад сургуульдаа ажиллаагүй тохиолдолд төлбөрийг буцаан төлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй 0.3 сая төгрөгийн шатахуун олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн өглөг, татварын хэлтсийн тайлангаас 4.7 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд 6.7 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 1,513.2 сая төгрөгийн 55 мэдээллийг ил тод байршуулахаас 939.9 сая төгрөгийн 17 мэдээллийг ил тод байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайланд 6.9 сая төгрөгийн Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор, олон жилийн насжилттай 3.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.



#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |              | Үүнээс    |              |               |            |                 |             |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|--------------|-----------|--------------|---------------|------------|-----------------|-------------|---------|-----|
|     |                                     |                      |              | Залруулга |              | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |             | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн          | Тоо       | Дүн          | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн         | Тоо     | Дүн |
| 1   | МСҮТ                                | 16                   | 171.0        | 7         | 123.9        | 3             | 3.9        | 7               | 43.1        |         |     |
|     | Дүн                                 | <b>16</b>            | <b>171.0</b> | <b>7</b>  | <b>123.9</b> | <b>3</b>      | <b>3.9</b> | <b>7</b>        | <b>43.1</b> |         |     |



АВЛАГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

| № | Байгууллага, иргэн           | Үүссэн төрөл                                       | 2021 оны эцсийн<br>үлдэгдэл<br>/аудитлагдсан/ | Тулган баталгаажуулалт |                  | Насжилт              |                         | Үүнээс                     |                                |                   |
|---|------------------------------|----------------------------------------------------|-----------------------------------------------|------------------------|------------------|----------------------|-------------------------|----------------------------|--------------------------------|-------------------|
|   |                              |                                                    |                                               | Тооцоо нийлсэн<br>дүн  | Тооцоо нийлээгүй | наскилт 0-1<br>жил   | наскилт 1-с дээш<br>жил | Цалингийн нөхөн<br>олговор | эзэн холбогдох<br>тосдорхойгүй |                   |
| 1 | Сэндэр                       | Цалин                                              | 150,000.00                                    | 150,000.00             |                  | 150,000.00           |                         |                            |                                |                   |
| 2 | Г.Гансүх <РД:ДА76032833>     | ШШАвлага                                           | 5,114,142.00                                  | 5,114,142.00           |                  | 5,114,142.00         |                         | 5,114,142.00               |                                |                   |
| 3 | Л.Тувшинбат <РД:ДИО95061111> | Цалингийн урьдчилгаа                               | 337,610.00                                    | 337,610.00             |                  | 337,610.00           |                         |                            |                                |                   |
| 4 | Гансүх <РД:ДА76032833>       | Цалингийн урьдчилгаа                               | 1,909,174.00                                  | 1,909,174.00           |                  | 1,909,174.00         |                         |                            |                                |                   |
| 2 | Г.Гансүх <РД:ДА76032833>     | ШШАвлага                                           | 1,840,526.00                                  | 1,840,526.00           |                  | 1,840,526.00         |                         | 1,840,526.00               |                                |                   |
| 5 | МСУТөв <РД:9014721>          | Цалин                                              | 456,534.00                                    | 456,534.00             |                  | 456,534.00           |                         |                            | 456,534.00                     |                   |
| 6 | ДЦЗэрмаа <РД:ДЭ72052607>     | 33520 - Хувь хүмүүсээс авах ач<br>бариа мат авлага | 241,000.00                                    | 241,000.00             |                  | 241,000.00           |                         |                            |                                |                   |
| 7 | Энхчулуун                    |                                                    | 326,115.00                                    | 326,115.00             |                  | 326,115.00           |                         |                            |                                |                   |
|   | <b>Авлагын дүн</b>           |                                                    | <b>10,375,101.00</b>                          | <b>10,375,101.00</b>   | <b>-</b>         | <b>10,375,101.00</b> | <b>326,115.00</b>       | <b>10,048,986.00</b>       | <b>6,954,668.00</b>            | <b>456,534.00</b> |
|   |                              |                                                    | 10,375,101.00                                 |                        |                  |                      |                         |                            |                                |                   |

2021 оны 01-12 сарын мөнгөн хөрөнгөөс шилжсэн дүнг  
төлбөрийн баримттай тулгасан байдал

| Харилцагчийн нэр                        | Мөнгөн хөрөнгөөр гарсан дүн | И-баримтаар орж ирсэн худалдан авалтын дүн | Зөрүү        | Зөрүү үүссэн харилцагч тус бүрт өгөх нягтлан бодогчийн тайлбар                   | Аудитаар шивүүлсэн | Илүү         | Эцсийн байдлаарх төлбөрийн баримтгүй дүн |
|-----------------------------------------|-----------------------------|--------------------------------------------|--------------|----------------------------------------------------------------------------------|--------------------|--------------|------------------------------------------|
| А.Баярцэцэг - ДЮ84062804                | 105,500.00                  |                                            | 105,500.00   | Давхар шивэгдсэн байна.                                                          |                    |              |                                          |
| +МГЖ-хуулга ID395                       | 192,000.00                  |                                            | 192,000.00   |                                                                                  |                    |              |                                          |
| <b>ААНААМАНДАХ</b>                      | 1,992,600.00                | 3,985,200.00                               | -            |                                                                                  |                    | 1,992,600.00 |                                          |
| Автотээврийн үндэсний төв               | 477,200.00                  | 477,200.00                                 | -            |                                                                                  |                    |              |                                          |
| АИ ТИ КЭЙР                              | 2,497,000.00                | 2,497,000.00                               | -            |                                                                                  |                    |              |                                          |
| Ай Эф Ти Софт ХХК - 6339654             | 3,000,000.00                |                                            | 3,000,000.00 | ярьсан.                                                                          |                    |              | 3,000,000.00                             |
| Алтай хотын тохижилт үйлчилгээний газар | 140,000.00                  | 140,000.00                                 | -            |                                                                                  |                    |              |                                          |
| Алтайннуруун шонхор                     | 70,000.00                   | 70,000.00                                  | -            |                                                                                  |                    |              |                                          |
